



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

“UB ART FAIR -2011” ДҮРСЛЭХ УРЛАГЫН ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 4/22 дугаар тогтоол, 2005 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Улаанбаатар хотын аялал жуулчлал -2015” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах Улаанбаатар хот, хотын орчимд жуулчдын сонирхолыг татах үзэсгэлэн яармаг зохион байгуулж гадаад, дотоодын жуулчидад сурталчилан таниулах зорилгоор Нийслэл хот үүсч байгуулагдсаны 372 жилийн ойг угтан “UB ART FAIR -2011” дүрслэх урлагын үзэсгэлэнг 2011 оны 10 сарын 12-ноос 16-ны өдрүүдэд Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагын музейд зохион байгуулахыг тус газрын эвент хариуцсан мэргэжилтэн /Г.Нямцогт/ -д үүрэг болгосугай.

Хоёр. Нийслэл хот үүсч байгуулагдсаны 372 жилийн ойг угтан “UB ART FAIR - 2011” дүрслэх урлагын үзэсгэлэнг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, үйл ажиллагааны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Нийслэл хот үүсч байгуулагдсаны 372 жилийн ойг угтан “UB ART FAIR - 2011” дүрслэх урлагын үзэсгэлэнг зохион байгуулах зардал 1.800.000 /нэг сая найман зуун мянга/ төгрөгийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2011 оны батлагдсан төсөв, төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас гаргахыг нягтлан /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Дээрх арга хэмжээг хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь амжилттай зохион байгуулж, олон нийтэд хэвлэл мэдээллээр сурталчилах, хяналт тавих, шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг тус газрын ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

11105000002